



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/517

Номгон

Баянцагаан суманд бохир соруулах автомашин
худалдан авах” ажлыг эрх шилжүүлэн
гүйцэтгүүлэх тухай


Монгол улсын Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /а/ дахь заалтыг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Баянцагаан суманд бохир соруулах автомашин худалдан авах” ажлыг тус сумын Засаг даргын Тамгын газарт эрх шилжүүлж гүйцэтгүүлсүгэй.

2.Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Баянцагаан сумын Засаг дарга /Н.Гансүх /-д үүрэг болгосугай.

3.Дээрх 25,000,000 /Хорин таван сая/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т зөвшөөрсүгэй.

4.“Баянцагаан суманд бохир соруулах автомашин худалдан авах” ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

6 1 10193